



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/306

Хэрлэн сум

Тэмцээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Бага дунд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны “Спортын наадам хойшлуулах тухай” 268 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.2.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Баянхонгор аймагт зохион байгуулагдах Монголын Хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнд баг тамирчдыг оролцуулахад 50,000,000 (тавин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Үндэсний болон спортын их наадмыг зохион байгуулах” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

4. Монголын Хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнд өсвөрийн тамирчдыг оролцуулах боломж нөхцөлөөр хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Мөнхцэцэг)-д, эрүүл ахуй, тээвэрлэлт зэрэг хүүхэд бүрийн аюулгүй байдлыг хангаж, наадмын шигшээ тэмцээнд өсвөрийн тамирчдаа амжилттай оролцуулахыг Биеийн тамир, спортын газрын дарга (Г.Нэргүйбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010791